



## Хураангуй

- Тариаланчдын байгаль, цаг уурын эрсдэл даах чадварыг сайжруулах;
- Тариалангийн даатгал нь эрсдэлийн менежментийг сайжруулах боломжтой;
- Индексжүүлсэн даатгалын үнэ нь харьцангуй хямд байх боломжтой;
- Малын индексжүүлсэн даатгалыг хэрэгжүүлэх явцад олж авсан туршлага, мэдлэгт тулгуурлан тариалангийн индексжүүлсэн даатгалыг нэвтрүүлэх;

## Монгол улсад тариалангийн индексжүүлсэн даатгалыг хөгжүүлэх нь

### Газар тариалангийн үйлдвэрлэл ба байгаль, цаг уурын эрсдэлүүд

Монгол улсад хөдөө аж ахуйн салбар нь хүнсний аюулгүй байдал төдийгүй хөдөөгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Өнөөгийн байдлаар Монгол улсын нийт хүн амын 28.2 хувь нь хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөр эрхэлдэг боловч тус салбарын бүтээмж төдийлөн өндөр биш байна. Монгол улсын Засгийн газраас газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Хөдөө аж ахуйг дэмжих санг байгуулж, тариалан эрхлэгчдэд төрөл бүрийн татаас, дэмжлэг, зээл урамшуулал олгон ажиллаж байна. Монгол оронд жилд дунджаар 525 мянган га-д тариалалт хийдгээс 390.9 мянган га-д улаан бүүдай тариалж байна (Тогтвортой хөдөө аж ахуй төсөл, 2016 он). Байгаль, цаг уурын эрс тэрс уур амьсгалаас шалтгаалан Монгол оронд тариалалтын улирал богино, жилд орох хур тунадасны хэмжээ бага байдаг нь газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхэд төдийлөн тохиромжтой биш юм. Тухайлбал, нутгийн өмнөд болон баруун хэсгээр жилд дунджаар 110-140 мм, зүүн хэсэгт 200-230 мм, хойд хэсэгт 220-350 мм хур тунадас ордог байна.

Implemented by





Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр сүүлийн жилүүдэд хуурайшилт улам бүр ихэсч байгаа нь тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хүндээр тусч байна. Тухайлбал, 2017 онд нутгийн ихэнх хэсэгт гандуу, хуурай байснаас ургац алдах гол шалтгаан болжээ. Байгаль, цаг уурын энэхүү хүнд хэцүү нөхцөлөөс шалтгаалан ургац алдах нь дан ганц тариаланчдад төдийгүй улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж, улмаар тус салбарт хэрэгжиж буй төрийн санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүдэд ихээхэн бэрхшээл үүсгэж байна. Энэ нь тариаланчдыг газар тариалангийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулах сэдлийг бууруулаад зогсохгүй дараа дараагийн жилүүдэд төрөөс олгох зээл, тусламжид ч томоохон хүндрэл үүсгэх эрсдэлтэй. Иймд Монгол улсын Засгийн газраас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн байгаль, цаг уураас хамаарах шууд хамаарлыг багасгах замаар хүнсний хангамжийг сайжруулах тогтворжуулах зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна. Тус зорилгын хүрээнд авч хэрэгжүүлэх хамгийн чухал ажлуудын нэг нь тариалангийн үйлдвэрлэлд даатгалын тогтолцоог нэвтрүүлэх явдал юм. Газар тариалангийн салбарт даатгалын системийг цогцоор нь нэвтрүүлсэнээр тус салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлээд зогсохгүй, бүтээмжийг нь дээшлүүлэх боломжтой бөгөөд энэ нь улмаар хүнсний хангамжийг тогтвортой байлгахад томоохон хувь нэмэр оруулах юм.

### **Байгаль, цаг уурын эрсдэлийг удирдахад тариалангийн даатгалын үүрэг**

Тариалангийн даатгал нь тариаланчид төдийгүй хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бүхий л иргэд, аж ахуйн нэгжүүдийн эрсдэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх зорилготой нэг төрлийн санхүүгийн хэрэглүүр юм. Даатгалын бүтээгдэхүүн нь газар тариаланд учирч буй эрсдэлийг даатгалын зах зээлд шилжүүлсэнээр тариаланчдийн итгэл нэмэгдэж, баталгаатай хөрөнгө оруулалт хийх боломжийг нэмэгдүүлдэг. Тариаланчид өөрийн бүтээгдэхүүнээ даатгуулсан тохиолдолд, зээл авах боломж нь нэмэгддэг байна. Газар тариалан, хөдөө аж ахуйн салбар нь эрсдэл өндөртэй байдгаас банк, санхүүгийн байгууллагууд тариалан эрхлэгчдэд зээл олгохоос татгалзах магадлал өндөртэй байдаг билээ. Иймд даатгуулсан аж ахуйн нэгжүүд банк санхүүгийн байгууллагуудаас зээл авч, хөрөнгө оруулалт хийх замаар үйлдвэрлэлээ эрчимжүүлж, технологую сайжруулах боломжтой болдог бол улмаар улс орны хэмжээнд хүнсний хангамжийг баталгаажуулах боломжийг бүрдүүлнэ. Иймд ялангуяа хөгжиж буй улс орнуудын хувьд тариалангийн даатгал нь тариаланчдад ашигтай байхаас гадна хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд бүхэлд нь эерэг нөлөө үзүүлэх боломжтой юм.

Онолын хувьд маш амжилттай хэрэгжиж болохуйц зарим нэгэн даатгалын бүтээгдэхүүнүүд хөгжиж буй орнуудад төдийлөн үр дүн авчраагүй. Үүний хамгийн том шалтгаан нь хөдөө аж ахуйн уламжлалт даатгалын үйл ажиллагааны зардал хэт өндөр байсан учир тариаланчид тус



даатгалын бүтээгдэхүүнийг худалдаж авч чадахгүй байсантай холбоотой юм. Мөн даатгалын компаниудад үл итгэх байдал, ёс суртахууны айдас, аюул зэрэг нь шилжилтийн эдийн засагтай орнуудад тариалангийн уламжлалт даатгал хэрэгжихэд томоохон сорил, бэрхшээлүүдийг дагуулж байв. Иймд тариалангийн уламжлалт даатгалын бүтээгдэхүүнийг орлох шинэ төрлийн бүтээгдэхүүн болох “Тариалангийн индексжүүлсэн даатгал” нь үйл ажиллагааны зардлыг бууруулаад зогсохгүй тариаланчид болон даатгалын компаниудын бие биеэдээ итгэх итгэлийг сэргээж өгсөн юм. Учир нь нөхөн олговрын хэмжээг хур тунадас, агаарын дундаж температур, нутгийн дундаж ургац зэрэг цаг агаарын индексүүдийн тусламжтай тодорхойлдог бөгөөд энэхүү мэдээлэлд тариаланч, даатгалын компанийн аль аль нь нөлөөлөх боломжгүй юм. Ийм төрлийн индексжүүлсэн даатгал нь индексийн босго түвшин тогтоодог ба хохирлын хэмжээг тухайн түвшинтэй харьцуулах замаар нөхөн төлбөрийн хэмжээг тооцдог. Монгол улс нь мал аж ахуйн салбартаа олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрүүдийн дэмжлэгтэйгээр малын индексжүүлсэн даатгалыг амжилттай хөгжүүлж чадсан анхдагч орнуудын нэг юм.

### **Малын индексжүүлсэн даатгал**

Монгол орны нүүдэлчин ахуй, соёл уламжлалтай нягт үялдаатай, хөдөө аж ахуйн салбарын хамгийн чухал нэг хэсэг нь мал аж ахуйн салбар юм. Тус салбар нь хүн амын хүнсний хангамжийг баталгаажуулаад зогсохгүй хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд нэн чухал үүрэгтэй юм. Байгаль, цаг уурын эрс тэс үүр амьсгалаас шалтгаалан тус салбарт малын хорогдол өндөр байдаг байна. Энэ нь дан ганц малчдад хүндээр тусахаас гадна улс орны хүнсний хангамжид ч томоохон хүндрэл үүсгэх эрсдэлтэй юм. Иймд Монгол улсын Засгийн газраас Дэлхийн банкттай хамтран мал аж ахуйн салбарт учирч буй эрсдэлийг бууруулах зорилгоор малын индексжүүлсэн даатгалын тогтолцоог нэвтрүүлээд байна. Индексжүүлсэн даатгалын гол онцлог нь индексийн босго түвшин тогтоодог ба хохирлын хэмжээг тооцохдоо тухайн түвшинтэй харьцуулах замаар нөхөн төлбөрийн хэмжээг тооцдог. Ихэнх индексжүүлсэн даатгал нь цаг агаарын индекс эсвэл бүс нутгийн бүтээмжийн үзүүлэлт дээр үндэслэн хийгддэг бөгөөд энэ нь малчдын хохирлын хэмжээтэй шууд хамааралтай байдаг. Өөрөөр хэлбэл малчдад учирсан бодит хохирлоор бус, даатгалын хамрах хугацаанд сумын хэмжээнд гарсан малын хорогдлын хувь босго үзүүлэлтээс давсан тохиолдолд даатгуулагчид нөхөн төлбөр олгодог. Даатгалын бүтээгдэхүүний үнийг хямд байлгах үүднээс Засгийн газар тодорхой хэмжээний татаас өгч байна. Ялангуяа, байгаль, цаг уурын гэнэтийн гамшигаас үүдэлтэй ихээхэн хэмжээний хохирол учирсан тохиолдолд даатгалын шимтгэлийг төрөөс шууд бус татаас хэлбэрээр олгодог. Энэ нь нөхөн олговрын төлбөрийг хоёр түвшинд




хуваах замаар хэрэгждэг бөгөөд нэгдүгээр түвшинд алдагдлыг 30% хүртэл (зарим нэгэн эрсдэлтэй бүс нутагт 20% хүртэл) нөхөн олгодог байна. Энэ тохиолдолд олон улсын давхар даатгалын компаниудын хуримтлуулсан шимтгэлээс нөхөн төлбөрийг гаргадаг. Харин 20% эсвэл 30%-иас дээш гарсан хохирлын нөхөн төлбөрийг төрөөс татаас хэлбэрээр санхүүжүүлж байна. Иймд даатгалын бүтээгдэхүүний үнэ нь Монголын малчдад боломжийн хэвээр байна. Монгол улсын Засгийн газраас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг байгаль, цаг уурын эрсдэлүүдээс хамгаалах зорилгоор ойрын жилүүдэд тариалангийн даатгалын зах зээлийг хөгжүүлэхээр зорин ажиллаж байна. Тариалангийн даатгалыг нэвтрүүлэхэд төрийн оролцоо, үүрэг хариуцлагыг тодорхойлохдоо шилжилтийн эдийн засагтай бусад орнуудын туршлага, мэдлэгээс суралцаж, Монгол орны нөхцөлд авч хэрэгжүүлэх боломжтой механизмуудыг судлах шаардлагатай юм.

#### **Шилжилтийн эдийн засагтай хөрш орнуудын туршлага**

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудаас өнөөдөр Казакстан, ОХУ, Украин, Узбекистан улсуудад тариалангийн даатгалын зах зээл ямарваа нэгэн байдлаар бүрэлдэн тогтсон ба үүнд төрийн татаас, дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэхдээ улс орон бүрийн үзүүлж буй төрийн татаас, дэмжлэгийн хэлбэр, хэмжээ харилцан адилгүй. Тухайлбал, Казакстан улсын хувьд тариалангийн даатгал нь албан журмын даатгалын хэлбэртэй ба тариаланчид тариалангийн даатгалд багтсан бүхий л эрсдэлүүдийг заавал даатгуулдаг. Тус даатгалд төрөөс татаас олгодог бөгөөд даатгалын компаниудын хохирлын 50%-ийг төр дангаараа хариуцдаг байна. 2016 оны байдлаар нийт талбайн 57% даатгалд хамрагдсан байсан (КазАгро, 2016) боловч даатгалын бүтээгдэхүүний үр нөлөө хангалтгүй байна. Учир нь төрөөс тавьж буй шаардлагыг биелүүлэхийн тулд тариаланчид албан журмын даатгалд маш бага хэмжээний хураамж төлдөг ба тус багахан хэмжээний хураамжаар алдагдлыг нөхөж чадахааргүй байдалд хүрчээ. Өөрөөр хэлбэл Казакстан улсад хэрэгжиж буй тариалангийн даатгал нь эрсдэлийн менежментийн оновчтой шийдэл болж чадахгүй байна.

Харин ОХУ-д даатгалын хураамжийн 50%-ийг төрөөс татаас хэлбэрээр олгодог ба даатгуулсан талбайн хэмжээ нь тухайн жилд олгох төрийн татаасаас хамааран 5%- 20%-ийн хооронд хэлбэлздэг байна. Иймд тариалангийн даатгалын амжилт нь тухайн жилийн төрөөс олгох татаасын хэмжээ болон тариаланчдын даатгалын бүтээгдэхүүн худалдаж авах хүсэл сонирголоос шүүд хамаардаг байна. Энэхүү даатгал нь төдийлөн амжилттай хэрэгжихгүй байгаагийн гол шалтгаан нь үйл ажиллагааны зардал маш өндөр бөгөөд эрсдэлийн менежментийн үр нөлөө тааруу байгаатай холбон тайлбарлаж болно (Бобоёнов нар, 2014).



Украин улс 2005-2008 онуудад даатгалын хураамжийн 50%-ийг татаас хэлбэрээр олгож байсан бол 2009 оноос төсвийн алдагдалтай холбоотойгоор энэхүү татаасыг зогсоосон байдаг. Өнөөдрийн байдлаар тус улсад газар нутгийн онцлогоос шалтгаалан нийт талбайн 8%-аас 18% нь даатгалд хамрагдаж байна (ОУСК, 2017). Украинд тариалангийн үйлдвэрлэл эрхлэх нь өндөр эрсдэлтэйд тооцогддог бөгөөд банкууд зээл олгохдоо заавал даатгуулсан байхыг шаарддаг боловч тариалангийн даатгалын эрэлт хэрэгцээ жилээс жилд буурч байна. Тус даатгалын бүтээгдэхүүнийг эрсдэлийн менежментийн сонирхолтой хэрэгсэл болгохын тулд үр ашгийг нь сайжруулах хэрэгцээ шаардлага нэгэнт бий болжээ. Үүсээд байгаа энэхүү нөхцөл байдлыг даван туулахын тулд хэд хэдэн олон улсын байгууллагууд Украин улсад тариалангийн индексжүүлсэн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж байгаа боловч хараахан бодит үр дүнд хүрээгүй байна.

Узбекистан улсын хувьд 1990-ээд оны эхээс 2002 он хүртэл тариалангийн даатгалд төрөөс 25% -ийн татаас, урамшуулал олгож байсан бол 2002 оноос хойш даатгалын бүтээгдэхүүн нь зах зээлийнхээ зарчимаар явах ёстой гэж үзжээ. Бүс нутгийн онцлогоос хамааран хөвөнгийн тариалангийн талбайн нийт 3%-аас 60%, улаан буудайн талбайн 2%-оос 37% тус тус даатгуулсан байдаг байна. (Муратуллаев нар, 2015). Тус улсад нэрлэсэн эрсдэлт даатгалын бүтээгдэхүүн зах зээл дээр голлох байр суурьтай байдаг боловч гангийн эрсдэлийг хамгаалдаггүй байна. Учир нь гангийн эрсдэлийг даатгах нь даатгалын бүтээгдэхүүний үнийг өсгөхөөс гадна тус улсын байгаль цаг уурын онцлог нь өөрөө гандуу, хуурай байдагтай холбоотой юм.

Шилжилтийн эдийн засагтай бусад орнуудын туршлагаас харахад даатгалын зах зээлийн хөгжил нь төрийн татаасаас ихээхэн хамаардаг байна. Газар нутгийн онцлогоос шалтгаалан тухайн улс орнуудад үйл ажиллагааны болон засвар үйлчилгээний зардал маш өндөр байдаг



тул улсын татаас, дэмжлэггүйгээр энэ салбарт үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг байна. Зөвхөн тодорхой хэдэн төрлийн эрсдэлүүдийг хамгаалсан эсвэл банкнаас зээл авахад заавал даатгуулсан байх ёстой гэсэн шаардлага тавьсан тохиолдолд л тариаланчид даатгалын бүтээгдэхүүнийг авч ашиглаж байна. Хэд хэдэн улс орнуудад тариалангийн индексжүүлсэн даатгалыг нэвтрүүлэх ажлууд дөнгөж эхний шатандаа явж байна.

### **Монгол улсад тариалангийн даатгалын нэвтрүүлэх нөхцөл, боломж**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), даатгалын болон давхар даатгалын компаниуд, Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн, аж ахуйн нэгж, тариаланчидтай уулзалт ярилцлагууд хийх явцад тариалангийн даатгалын зах зээлийг хөгжүүлэхийн ач холбогдлыг бүгд санал нэгтэйгээр дэмжиж байлаа. Тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг хямд, хүртээмжтэй байлгах үүднээс төрөөс даатгалын компаниудад болон тариаланчдад татаас өгөх асуудлыг ч мөн холбогдох байгууллагуудын зүгээс дэмжиж буйгаа илэрхийлж байсан. Мөн даатгалын болон давхар даатгалын компаниуд нь “Малын индексжүүлсэн даатгал”-аар дамжуулан хөдөө аж ахуйн салбарт хангалттай туршлага, мэдлэг хуримтлуулжээ. Тариалангийн даатгалыг 2016-2017 онуудад цөөн хэдэн тариаланчидтай хамтран туршилтын хэлбэрээр хэрэгжүүлсэн байна. Тус туршилтаас харахад Монгол улсад тариалангийн уламжлалт даатгал нь маш үнэтэй тусахаар байсан тул, тариалангийн индексжүүлсэн даатгалын хувилбарыг нэвтрүүлэх боломжийг судалж, оролцогч талуудын уулзалт, хэлэлцүүлгүүд үргэлжилж байна. Тус уулзалт хэлэлцүүлгээс харахад тариалангийн индексжүүлсэн даатгал нь төрийн байгууллагууд болон хувийн даатгалын компаниудын зүгээс дэмжигдэж, өндөр хүлээлт үүсгээд байна. Тариалангийн индексжүүлсэн даатгалыг амжилттай эхлүүлж, тогтвортой хөгжүүлэхийн тулд нэн тэргүүнд хэд хэдэн чухал асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Тариалан эрхлэгчидтэй хийсэн ярилцлагуудын үр дүн нь харилцан адилгүй гарсан бөгөөд зарим нэгэн тариаланчид даатгалын бүтээгдэхүүнийг ихээр сонирхож байхад зарим нь огт сонирхохгүй байлаа. Эдгээр ярилцлагуудын үеэр анхаарал татаж байсан өөр нэг асуудал нь хөдөө аж ахуйн зөвлөх үйлчилгээний (экстейншин) мэргэжилтнүүд дутагдалтай байгаа нь ажиглагдсан. Тариалангийн даатгалын системийг цогцоор нь нэвтрүүлэх асуудал яригдаж байгаа өнөөгийн нөхцөлд эрдэм шинжилгээний байгууллагууд, ус цаг уурын станц зэрэг салбарын бусад байгууллагуудын оролцоо дутмаг байгааг дараа дараагийн хэлэлцүүлгийн үеэр анхаарах шаардлагатай юм.



### **Бодлогын зөвлөмж**

Тариалангийн даатгалыг нэвтрүүлэх нөхцөл байдлын үнэлгээн дээрээс харахад тариалангийн даатгалыг туршилтын байдлаар улсын хэмжээнд, өргөн хүрээнд хэрэгжүүлэхэд институцийн таатай орчин бүрдэж байна. Тус даатгалын тогтолцоог нэвтрүүлэхэд төрөөс үзүүлэх татаас, урамшууллын механизмыг бүрдүүлэхдээ хэд хэдэн зүйлийг зайлшгүй анхаарах нь чухал юм. Үүнд нэгдүгээрт, улсын татаас, урамшууллын хэлбэр, хэмжээг сонгохдоо туйлын болгоомжтой хандах хэрэгтэй бөгөөд ялангуяа хөрш зэргэлдээ орнуудын жишээг харж, тэдний алдаа онооноос суралцах нь зүйтэй юм. Даатгалын хураамж дээр улсаас татаас олгох нь анх хүлээж байсан үр дүнг авчраагүй, харин ч эсрэгээрээ зах зээлийн механизмыг улам хүндрүүлсэн жишээнүүд бий. Иймд төрөөс олгох татаасаа хэрхэн ямар хэлбэрээр олгох вэ гэдгийг нарийн тооцоолох, тухайлбал “Малын индексжүүлсэн даатгал”-ын зарчмыг баримтлах эсвэл даатгалын болон давхар даатгалын компаниудын үйл ажиллагааны зардлыг нөхөх хэлбэрээр олгох боломжтой юм. Энэ төрлийн татаасын хэлбэр нь Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) зэрэг олон улсын байгууллагуудтай байгуулсан гэрээ хэлэлцээний үүргүүдтэй нийцэх боломжтой юм. Анхаарах шаардлагатай өөр нэг чухал асуудал бол тариалангийн даатгал нь хэзээ ч албан журмын даатгал байж болохгүй бөгөөд тариаланчид сайн дураараа, өөрийн сонирхолд нийцүүлсэн тус даатгалын бүтээгдэхүүнийг авдаг байх хэрэгтэй. Улмаар байгаль, цаг уурын эрсдэл, тариалангийн даатгалын ашиг тусын талаар тариаланчдын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай бөгөөд энэ чиглэлээр төрөөс зөвлөх үйлчилгээний буюу экстейншины мэргэжилтнүүдийг бодлогоор бэлдэх нь чухал юм. Даатгалын бүтээгдэхүүнийг даатгуулагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тасралтгүй хөгжүүлж, сайжруулж байх нь нэн чухал бөгөөд үүний тулд тариаланчдаас тогтмол судалгаа, мэдээлэл авдаг, тэдэнтэй байнгын харилцаа холбоотой байх шаардлагатай. Ийнхүү тариалангийн даатгалын талаар хүмүүс илүү зөв ойлголт, мэдээлэлтэй болсоноор тус бүтээгдэхүүн нь зах зээл дээр илүү удаан оршин тогтнох боломжтой болно. Эцэст нь тариалангийн индексжүүлсэн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх явцад Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

**Ашигласан хэвлэл:**

- KazAgro, 2007. Data on mandatory crop insurance. Source <http://www.kazagro.kz>. Accessed 08.09.2017.
- IFC, 2017. Overview of agricultural insurance in Ukraine for underwriting year 2015-2016. IFC Report
- Muradullayev, N., Bobojonov, I., Mustafaqulov, S., 2015. Current state and future prospects of crop insurance in Uzbekistan. Paper prepared for presentation at the “Regional Economic Cooperation in Central Asia: Agricultural Production and Trade (ReCCA)” conference. November 24 to 26, 2014. Halle (Saale), Germany.

**Зохиогч:****Др. И. Бобоёнов**

Шилжилтийн эдийн засагтай орнуудын хөдөө аж ахуйн хөгжлийн хүрээлэн (IAMO), ХБНГУ

**Тайлбар:** Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 16-01) төслийг санхүүжүүлэгч Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.